

“Инновэйшн Инвестмент” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын
2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 05/13 тоот тогтоолын
01 дугаар хавсралтаар батлав



“ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ” ХК НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү бодлогын зорилго нь “Инновэйшн Инвестмент” ХК-ийн (цаашид “компани” гэх) Төлөөлөн удирдах зөвлөлөөс ногдол ашиг хуваарилахад баримтлах бодлогыг тодорхойлох, хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах нөхцөл, журмыг “Компанийн тухай” хууль болон Компанийн дүрэм, Компанийн засаглалын кодекст нийцүүлэн тогтоох, ногдол ашиг хуваарилах шийдвэр гаргах, энэ талаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх, ногдол ашгийг төлөх, тайлагнахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Компани нь үйл ажиллагаандаа дотоодод хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Компанийн засаглалын кодексыг мөрдөж ажиллана.
- 1.3. ТУЗ нь “Ногдол ашгийн бодлого”-ыг хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэх, танилцуулах үүрэгтэй ба ТУЗ-ийн нарийн бичгийн дарга уг баримттай танилцах боломж олгоно.
- 1.4. Бодлогын зорилт:
 - 1.4.1. хувьцаа эзэмшигчийн эрхийг баталгаажуулах;
 - 1.4.2. ашгийг тэгш, шу даргаар хуваарилах;
 - 1.4.3. тайлагнал, мэдээллийн ил тод байдлыг сайжруулах;
 - 1.4.4. эрсдэлийн удирдлагыг сайжруулах;
 - 1.4.5. хяналтын тогтолцоог сайжруулах.
 - 1.4.6. засаглалын сургалтад хамруулах;
 - 1.4.7. Бодлогын хэрэгжилтийг тайлагнах, мэдээлэх.

ХОЁР. НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ НӨХЦӨЛ, ЖУРАМ

- 2.1. Нэг төрлийн нэгж хувьцаанд адил хэмжээний ногдол ашиг хуваарилна.
- 2.2. Компани дор дурьдсан тохиолдолд ногдол ашиг хуваарилж болно. Үүнд:
 - 2.2.1. ногдол ашиг төлсний дараа компани төлбөрийн чадвартай байх;

- 2.2.2. Компани нь тухайн санхүүгийн жилд бусдад төлөх бүх өр, төлбөрийг бүрэн төлсний дараа ашигтай байх;
 - 2.2.3. ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгө нь давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, татан буулгах үед төлөх дүн, компанийн дүрэмд заасан хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээний нийлбэрээс илүү байх;
 - 2.2.4. компани хувьцаа эзэмшигчдийн шаардлагаар хувьцаагаа эргүүлэн авах нөхцөл байдал үүссэн, өрийн бичгээ эргүүлэн худалдан авах хугацаа болсон бол эдгээр үнэт цаасыг бүрэн эргүүлэн авсан, эсхүл бүрэн худалдан авахад шаардагдах хөрөнгөтэй байх.
- 2.3. Ногдол ашгийг компанийн татвар төлсний дараах цэвэр ашгаас хуваарилна.
 - 2.4. Ногдол ашиг тараах хэлбэр ба хугацаа нь хувьцаа эзэмшигчдийн эрх ашигт нийцсэн, холбогдох хууль тогтоомж, эрх бүхий байгууллагын баталсан журам, зааврыг зөвлөмжийг баримталсан байна.
 - 2.5. Компани нь эргүүлэн худалдаж авсан өөрийн хувьцаанд ногдол ашиг хуваарилахгүй.

ГУРАВ. НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ ТУХАЙ ШИЙДВЭР

- 3.1. Ногдол ашиг хуваарилах шийдвэрийг тухайн жилийн санхүүгийн тайланг хөндлөнгийн аудитаар баталгаажуулснаас хойш 50 хоногийн дотор ТУЗ гаргана.
- 3.2. Ногдол ашиг хуваарилах шийдвэрт дараах зүйлсийг тусгасан байна:
 - 3.2.1. Нэгж хувьцаанд ногдох ногдол ашгийн хэмжээ;
 - 3.2.2. Ногдол ашиг төлөх өдөр;
 - 3.2.3. Ногдол ашиг төлөх хэлбэр (бэлэн мөнгө, эд хөрөнгө, үнэт цаас гэх мэт);
 - 3.2.4. Ногдол ашиг тараах хэлбэр;
 - 3.2.5. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрс гаргах бүртгэлийн өдөр.
- 3.3. Ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн тухай мэдээллийг Компанийн албан ёсны цахим хуудаст байршуулахаас гадна Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэдэг журмаар хувьцаа эзэмшигчдэд хүргэх ба үүнд дараах мэдээллийг тусгана:
 - 3.3.1. Тухайн төрлийн нэгж хувьцаанд ногдуулан хуваарилахаар шийдвэрлэсэн ногдол ашгийн хэмжээ;
 - 3.3.2. Бүртгэлийн өдөр;
 - 3.3.3. Ногдол ашиг төлөх хэлбэр;

- 3.3.4. Ногдол ашиг тарааж эхлэх огноо;
- 3.3.5. Ногдол ашиг тараах байгууллагын нэр, хаяг, ажиллах цагийн хуваарь, ногдол ашгийн талаар лавлагаа өгөх утасны дугаар зэрэг мэдээлэл.
- 3.4. Компани нь хувьцаат компани болох тохиолдолд энэ бодлогод дурдсан бүртгэлийн өдөр нь “Иновэйшн Инвестмент” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар мэдээ хүргэх журам” (хэрэв байгаа бол)-д заасан бүртгэлийн өдөртэй ижил байна.
- 3.5. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдрийг ТУЗ ногдол ашиг хуваарилах өдрөөр тогтооно.
- 3.6. Ногдол ашгийг улирал, хагас жил тутам олгож болох бөгөөд энэ тухай шийдвэрийг ТУЗ-ийн нийт гишүүдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ. Бүртгэлийн өдөр нь ногдол ашиг хуваарилах шийдвэрийг нийтэд зарласнаас хойш 14-21 дахь өдөр байна.
- 3.7. ТУЗ-өөс ногдол ашгийг тараах өдрийг тогтоохдоо компанийн бизнес төлөвлөгөөтэй уялдуулан боломжит хугацааг харгалзана. Ногдол ашиг төлөх өдөр нь ногдол ашиг тараах шийдвэр гарсан өдрөөс хойш 15 хоногоос хэтрэхгүй байна.
- 3.8. Ногдол ашгийг бэлэн мөнгө, эсхүл эд хөрөнгийн, түүнчлэн компанийн болон бусад этгээдийн үнэт цаасны хэлбэрээр төлж болно.
- 3.9. Ногдол ашиг хуваарилах эсэх тухай ТУЗ-ийн шийдвэрийг хувьцаа эзэмшигчид мэдэгдэж, Санхүүгийн зохицуулах хороонд мэдээлж, Хөрөнгийн биржийн мэдээллийн нэгдсэн санд хүргүүлнэ.
- 3.10. Жилийн тайланд тусгах мэдээлэлд ногдол ашгийн хэмжээг тодорхойлсон үндэслэл, төлөх журмын талаар бүрэн тусгасан байх бөгөөд ногдол ашиг хуваарилахгүйгээр шийдвэрлэсэн бол түүний үндэслэлийг энэ журмын дагуу тайлбарласан байна.
- 3.11. Компани ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн бол энэ тухайгаа хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд заавал тайлагнах бөгөөд тайлбартаа ногдол ашиг хуваарилах боломжгүй байдалд хүрсэн шалтгаан, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай тайлбар зэргийг тусгасан байна.

ДӨРӨВ. НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ, ТАЙЛАГНАХ

- 4.1. Ногдол ашиг төлөх хэлбэр, олгох хугацаа, журам нь хувьцаа эзэмшигчдэд аль болох тохиромжтой байна.
- 4.2. Ногдол ашиг төлөх өдөр хүртэлх хугацаанд Компанийн гаргасан хувьцааны тоо, эсхүл хувьцаа эзэмшилд өөрчлөлт орсон эсэхээс үл хамааран бүртгэлийн өдрөөр тасалбар болгон гаргасан хувьцаа эзэмшигчид ногдол ашгийг тараана.

- 4.3. Ногдол ашиг хуваарилсны дараа үлдэх татварын дараах цэвэр ашгийг хуримтлагдсан ашгийн дансанд хадгалан компанийн ирээдүйн өсөлтийг хангахад шаардлагатай өөрийн хөрөнгийн хүрэлцээг бүрдүүлнэ.
- 4.4. Ногдол ашиг тараасны дараа үлдэх ашгаас нийгмийн хариуцлага, соёлын арга хэмжээний санг ТУЗ-ийн шийдвэрээр байгуулж болно. Сан байгуулах, түүний хөрөнгийг захиран зарцуулах журмыг гүйцэтгэх удирдлага боловсруулж, ТУЗ-ийн тогтоолоор батална.
- 4.5. Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ногдол ашгийг ТУЗ-өөс тогтоосон хугацаанд төлөөгүйгээс компанид учирсан хохирлыг гүйцэтгэх захирал болон холбогдох бусад албан тушаалтнууд хариуцна.
- 4.6. Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн шийдвэр гарсан бол төлбөл зохих ногдол ашгийн хэмжээг хувьцаа эзэмшигчдэд төлөх өр болгон нягтлан бодох бүртгэлд тусгах бөгөөд ногдол ашиг хуваарилж эхэлсэн улирлын эцэст ногдол ашгаа аваагүй байгаа хувьцаа эзэмшигч бүрийн нэрээр тусгайлан өглөгийн бүртгэл хөтөлнө. Компани нээлттэй хувьцаат компани болсны дараа ногдол ашгийг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-иар дамжуулан хувьцаа эзэмшигч бүрийн “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК дахь дансанд шилжүүлэх бодлого баримтална.
- 4.7. Ногдол ашиг хуваарилж эхэлсэн улирлын санхүүгийн тайлан гаргах үед “Ногдол ашгийн хуваарилалтын тайлан”-г Хувьцаа эзэмшигчдийн дараагийн хуралд танилцуулж, Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржид хүргүүлэх бөгөөд хувьцаа эзэмшигчдийн жилийн ээлжит хуралд өмнөх жилийн ногдол ашиг хуваарилалтын тайланг танилцуулна.

ТАВ. БУСАД

- 5.1. Ногдол ашгийн бодлогыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.
- 5.2. Энэхүү бодлогоор зохицуулаагүй бусад харилцааг Компанийн тухай хууль, Компанийн дүрэмд зааснаар дагаж мөрдөнө.

“ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ” ХК

---oOo---

АР ХОТ

ИЙШН
МЕНТ

48 90240702

**ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ ХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2024 оны 12 дугаар сарын 04-ний өдөр

Дугаар 05/13

Улаанбаатар хот

НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13, Компанийн дүрмийн 9.6.17 дугаар заалтыг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Инновэйшн Инвестмент ХК-ийн “Ногдол ашгийн бодлого”-ыг Хавсралт-1 ёсоор баталсугай.
2. Батлагдсан журмыг үйл ажиллагаандаа мөрдөн, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга болон гишүүд, Гүйцэтгэх захирал /Г.Эрдэнэменх/ нарт үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



А.БАТТАМИР